



**БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ ОНӨТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/Н

Улаанбаатар хот

**“Байгууллагын дэргэдэх Эцэг эхийн
зөвлөл”-ийн зөвлөл байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1.10 дахь заалт, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүүхдийг аливаа эрсдэлд өртөх, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийн хүмүүжил, эцэг эхийн хоорондын харилцаа, эрүүл зөв амьдралын хэвшил, хүүхдийн нийгэмд хандах хандлагыг төлөвшүүлэх үүрэг бүхий “Эцэг эхийн зөвлөл”-ийн гишүүдийг 1 дүгээр хавсралтаар, “Эцэг эхийн зөвлөлийн ажиллах журам”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хүүхэд, эцэг эх, гэр бүлийн хүмүүжлийн талаарх зөвлөмж, зөвлөгөө, мэдээллийг нийт ажилтан, албан хаагчдад хүргэхийг /Эцэг эхийн зөвлөл/-д даалгасугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг /Төслийн менежер/-т даалгасугай.

ДАРГА



Н.УУГАНБАЯР

“Бэлчээрийн менежмент-төслийн нэгж” орон нутгийн өмчит төсөвт
үйлдвэрийн газрын даргын 2021 оны 4 дугаар сарын 20 – ны
өдрийн 4 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Эцэг эхийн зөвлөлийн бүрэлдэхүүн

Зөвлөлийн дарга

Төслийн менежер

Гишүүн

Агрономч


Нярав

Тоног төхөөрөмжийн оператор

Нарийн бичиг

Хүний нөөц, бичиг хэргийн
мэргэжилтэн

“Бэлчээрийн менежмент-төслийн нэгж” орон нутгийн өмчит төсөвт
үйлдвэрийн газрын даргын 2021 оны ~~дугаар сарын 22~~ ны
өдрийн ~~14~~ дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



ЭЦЭГ ЭХИЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Эцэг эхийн зөвлөл цаашид “зөвлөл гэх”/ нь хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, хүүхдийг аливаа эрсдэлд өртөх, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, эцэг эхийн хоорондын харилцаа, нийгмийн хандлагыг төдөвшүүлэх чиглэлээр ажил зохион байгуулан ажиллах эцэг эхийн төлөөлөл юм.
- 1.2. Байгууллагын албан хаагчид нь зөвлөлийн хуралд саналаа илэрхийлэх, зохион байгуулж буй ажилд оролцох эрх, үүрэгтэй.
- 1.3. Зөвлөл нь зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын бүрэлдэхүүнтэй байна.
- 1.4. Зөвлөлийн хуралдааны талаар тэмдэглэл хөтөлнө. Тэмдэглэлд зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, тэмдэглэл хөтөлсөн хүн гарын үсэг зур баталгаажуулна.
- 1.5. Гишүүдийн гуравны хоёроос доошгүй ирцтэй үед зөвлөлийн хурлыг хүчин төгөлдөрт тооцож, асуудлыг олонхын саналаар шийдвэрлэнэ. Санал тэнцсэн тохиолдолд зөвлөлийн даргын саналаар шийдвэрлэнэ.
- 1.6. Зөвлөл нь гэр бүл хүүхдэд чиглэсэн бүхий л үйл ажиллагааг зохион байгуулан гэр бүлийн зөв харилцаа хандлага, хүүхдээ эерэг зөв аргаар хүмүүжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлнэ.

Хоёр. Чиглэл

- 2.1. Эрүүл зөв амьдралыг дэмжиж, хүүхэд эцэг эхчүүдэд чиглэсэн тогтоол шийдвэр, заавар зөвлөгөөг нийт ажилтан, албан хаагчдад мэдээлж сурталчлах
- 2.2. Зөвлөлөөс явуулж буй үйл ажиллагааг мэдээллийн самбар, цахим хуудсанд байршуулах
- 2.3. Эцэг эхийн зөвлөлөөс гарсан санал, шийдвэрүүдийг удирдагчид танилцуулж шийдвэрлүүлэх